

График дизайн

Б. Цогжавхлан

Харилцааны элемент
ба харааны элемент

ЭЛЕМЕНТ
РЕКЛАМ

Улаанбаатар
2009

Graphic DESIGN

Б. Цогжавхлан

**“Харилцааны элемент ба
харааны элемент”**

**“Дизайн дахь өнгө ба
гэрэл”**


График дизайны мэргэжлээр суралцдаг
суралцагчдад зориулав.

Редактор : док/рh/ Л. Моломжамц

Улаанбаатар хот 2009 он

Чөлөөт буюу үйлдэлтэй байгуулалтын онцлог

1. Үндсэн дүрсийг зургийн хавтгайд дүрсэлж түүнийг будсаны дараа ажиглахад тухайн зохиомж ямар байгуулалттай болох нь танигдах байж болно.



2. Үндсэн дүрс нь байгуулалтын нэгж бүрд орон зай, хэм чиглэлийн хувирал өөрчлөлттэй байж болно.

3. Үндсэн дүрс ба зургийн хавтгайг будахдаа харилцан солбицож байхаар байрлуулж болно. Мөн зарим дүрсийг арилгах буюу цагаан хараар нэмж зурах эсвэл урвуу байрлалтай ч байж болно.

4. Үндсэн дүрс нь байгуулалтын тигээс давж гарсан тохиолдолд илүү гарсан дүрсийг зохиомжид оруулахгүй байж болох талтай.

3. Өглөөний кофе лого – 13 мин / Лого хэрхэн хийх дараалалыг багш проектороор үзүүлэх /

“ Өглөөний кофе” кафены логог энгийн дүрслэл ашиглан хийх.


Лого хийхэд шаардлагатай дүрс, дүрслэл




1. инээж байгаа хүний дүрслэл



2. аяганы дүрслэл



- Энэ хялбар дүрслэлийг хооронд нь нийлүүлэн зохиомжлох юм бол дүрс таних тэмдэгний хэмжээнд очиж байна.



Нэрийг логоны доод талд тэгш хэмтэй хийж өгөх



MORNING COFFEE

- Логонд улаан шар өнгө өгч логог тодотгохын тулд хүрээ хийсэн байна.



**MORNING
COFFEE**

- Дэвсгэр хэсэгт өнгөний уусгалт хийсэн нь үндсэн улаан шар өнгийг улам тодотгон харуулж байна. Мөн дээрхи хэсэг нь таних тэмдэг мэт сэтгэгдэл төрүүлж байсан бол энэ логоны чанарыг илүүтэйгээр илтгэж байна.



**MORNING
COFFEE**

- Шрифтийн байрлал өөрчлөгдөж ерөнхий дизайны хувьд тэгш хэмтэй, дээр доор гэсэн сэтгэгдэлийг төрүүлж байна. Энэ хүнд дэндүү их эмх цэгцтэй дараалсан, ядмаг сэтгэглэгээг төрүүлж болох юм.



COFFEE

- Одоо харин лого нь хаяг, рекламны шинж төрхийг илтгэж зохиомжийн хувьд төгс төгөлдөр болсон байна.



5. "Adidas" -ын нэр болон логоны тайлбар



Adidas фирмийн үүсгэн байгуулагчийг Adolf Dassler гэдэг байжээ.1949 онд уг фирмийг үндэслэгч өөрийн нэрний эхний үеэс Adi-г хоёр дах үеэс Das хэмээх үеийг авч Adidas гэж нэрлэсэн түүхтэй юм. Харин Adidas –ын логоны учир нь Adolf Dassler 3 хүүтэй болохоор тэднийгээ төлөөлүүлэн 3 зураас эсвэл 3 дэлбээ бүхий логог зохиолгосон гэдэг. Ташуу 3 зураас нь 3 хүү насныхаа эрэмбээр байгаа санааг илэрхийлжээ.


6. **Дасгал ажил – 14 мин** / Баг тус бүр бодлого сэдвээр зохиомж хийх энэ нь янз бүрийн хэлбэр хийцтэй байж болох ч “Бодлого” гэсэн үгийн утгийг алдуулж болохгүй. Мөн энэ нь сурагчдад сайн бодож, сэтгэж байж хий гэсэн санааг төрүүлэх зорилготой /

- 3 Дүрснээс “БОДЛОГО” сэдэвтэй логог зохиомжлох







Зүй тогтолт буюу үйлдэлгүй байгууламжийн онцлог




зураг 6



зураг 7



зураг 8



зураг 9

1. Үндсэн дүрсээ байгууламжийн нэгж дотор гол тэнхлэгийн дагуу байрлуулна. Үндсэн дүрсээ байрлуулсны дараа дүрс зохиомжийг будахад байгуулалтын тэнхлэг зурааас арилж, ажиглагчийн нүдэнд анзаарагдахгүй болох юм. /зураг 6/
2. Байгуулалтад үндсэн дүрс зургийн хавтгайг будахдаа зөв ба урвуу дараалал хэмнэлийг эгнээ, эгнээгээр харилцан сольж байрлуулж болно. /зураг 7/
3. Үндсэн дүрсээ байгууламжийн тэнхлэгийн төв хэсэгт байгуулна. Ингэхэд байгууламжийн нэгжийн гол дахь хэлбэр дүрсэд их багын хувирал гарна. Ийм тохиолдолд байршилыг дахин хувиргах боломжгүй. /зураг 8/
4. Үндсэн дүрс байгуулалтын нэгжээс давсан тохиолдолд илүү хэсгийг зохиомжинд оруулахгүй байх жишээтэй. /зураг 9/



Ердийн байгуулалт гэдэг нь жам ёсны чанар нь тодорхой үзэгддэг хэвшмэл, зохиомж утга ойролцоо, аажмаар хувирсан, цацарсан байгууламжийг хэлнэ.

Ердийн бус байгууламж гэдэг нь ихэвчлэн байгуулалт нь төв рүүгээ тэмүүлж цугларсан, харилцааны элементийн орон зай, тодорхой ба тодорхой бус эсвэл зориудын зохиомжтой буюузохиомжгүй, хүндийн төв нь аажмаар шилжсэн, байгуулалтын ямар нэг тогтсон тиг баримжаа байхгүй байгууламжийг хэлдэг.


Иймээс зохиомжийн буюу цугларал, эрс тэрс ялгааг энгийн бус байгууламжинд тооцдог. Онцгой хувирал бол ердийн ба ердийн бус байгууламжийн завсрын нэгэн үзэгдэл юм.

Давтагдсан байгууламж

Давтагдсан байгууламжийн босоо ба хөндлөн шугамын хоорондох зай нь ижил хэмжээтэй хэмнэл үүсгэсэн байдаг. Хэрэв хөндлөн ба босоо шулуунуудын ижил хэмжээгээр давтагдах зайг өөрчилбөл, тэгш өнцөгтийн өөр чиглэлт давтагдсан байгууламж үүснэ. /зураг 10, 11/






Ойролцоо байгууламж



Ойролцоо дүрсийн байгууламж хувирал багатай байдаг ч үндсэн хэлбэрийн нэгж хоорондох зайг адил хэмжээгээр салаавчлан зөрүүлж давтагдан багуулагдах тохиолдлыг сонгож болно. /зураг 12/

Аажмаар хувирах байгууламж

Аажмаар хувирах байгууламж гэдэг нь байгуулалтын хөндлөн ба босоо шугамуудыг /нягт сийрэг/ хол, ойрын зай,




Зураг 13 зураг 14 зураг 15

харьцаагаар хүмүүст хөдөлгөөнт сэтгэгдэл төрүүлдэг байгууламж юм. Байгууламжийн хөндлөн болон босоо шугамын аль нэгийг нь нягт сийргийн харьцааг хувиргах аргыг дан элементийг аажим хувиргах арга гэнэ. Хэрэв байгуулалтын хөндлөн ба босоо шугамыг хоёуланг нь зэрэг хувиргасан байвал, түүнийг хос элементийн аажим хувиргалт гэнэ.


Зураасаар аажим хувиргах

Арга билгээр аажим хувиргах



/зураг16/

/зураг17/





Ер нь үндсэн дүрсийг чаажим хувиралтаар хувиргаж болно. Мөн төвд тэмүүлэх, төвөөс зугатах байгууламжийг хослуулан зохиомжилж болдог. Бас цацраг байгуулалтын давтагдсан хэмнэлийг үүсгэж, аажмаар хувирган зохиомжилж болно. Зурагт цацраг байгууламжийн төвөөс аажмаар цацран алслах хэлбэр үүсгэсэн зохиомжийг үзүүлэв. /зураг 18, 19/

Дээрх байгууламжийн шулуун шугамууд өргөн, нарийнтай байвал илүү хүчтэй илэрхийлэл болж харагдана. /зураг 20/ цацраг, шулууны гол цэг, чиглэлийг сайтар тооцож зурна.

Онцгой хувирлын байгууламж

Онцгой хувирлын байгууламж гэдэг нь давтагдсан байгууламжид ердийн олноор орших, ижил дүрсүүдийг оруулж хувирган зохиомжлохыг хэлнэ. Онцгой хувирлын байгууламж нь байгуулалтын үндсэн шугамын дагуу хувиргах үйлдэл юм. Онцгой хувирал нь:


Давталт	-	Онцгой хувиралт	-	Давталт
---------	---	-----------------	---	---------



гэсэн зарчмаар явагдана. /зураг 21, 22/

Төвлөрсөн байгууламж

Төвлөрсөн буюу цугларсан байгууламж нь голдуу аливаа дүрс хэлбэрийг зурахын өмнө зохиомжийн төв болгох цэг, шулууныг урьдчилан байгуулж, тэдгээрийг тойруулан үндсэн дүрсүүдийг зохион байгуулалттайгаар бөөгнөрүүлэх болон татраан байрлуулж зохиомж үүсгэхийг хэлнэ. /зураг 23/



Зураг 23 зураг 24 зураг 25 зураг 26

Харьцах элементийн тодорхой ба тодорхой бус, нягт ба сийрэг илэрхийлэл нь цугларсан байгууламжинд нарийн тооцогдсон байдаг. Цэгийг урьдчилан байрлуулж, түүнийг тойруулан зохиомжлох үйл ажиллагаа нь харьцуулан үзвэл цацрагийн байгуулалттай төсөөтэй. Харин шулууныг урьдчилан байгуулах нь аажим хувиралттай төстөй байдаг.


Үүнээс гадна тогтонги буюу хөдөлгөөнтэй цугларал гэж бий. Энэхүү байгууламжийн онцлог нь урьдчилан цэг шулууныг байрлуулахгүйгээр шууд зурах үйлдэл юм. Тогтонги болон хөдөлгөөнт цугларалт нь голдуу үндсэн дүрсүүдийн бөөгнөрөл, орон зай, тодорхой ба тодорхой бус зэрэг адилтгалын чанарыг гаргахад оршдог. /зураг 24-26/

Тогтонги ба хөдөлгөөнт цугларалыг хийхдээ зохиомжийн нэгдлийн хуулийг онцгой анхаарах шаардлагатай байдаг.

Харьцуулах ба жиших байгуулалт

Харьцуулах байгуулалтыг голдуу харьцааны элементүүдийн орон зай, тодорхой ба тодорхой бус дүрс шалтгаан, байх ба эс байх чанар, хүндийн төвийн байрлал, болон үндсэн дүрсүүдийг хооронд нь жиших үндсэн дээр зохиодог.

Орон зай, тодорхой ба тодорхой бус, байх ба эс байх, хүндийн төвийн байрлал үндсэн дүрсүүдийн адилтгалуудыг голдуу зохиомжуудыг жишин харьцуулах аргаар анализ хийж үзсэний дүнд гаргаж авна.



Зураг 27

зураг 28

зураг 29

зураг 30

Харьцуулалтыг гурван аргаар бүтээнэ. Үүнд:


1. Ойролцоо дүрсүүдийн байршил, орон зай, хүндийн төвийг жиших аргаар бүтээх. /зураг 28/
2. Зохиомж боловсруулах явцад өөр өөр үндсэн дүрсүүдийг хооронд нь жиших маягаар бүтээж болно. /зураг 29/
3. Зураасыг үндсэн дүрс болгон авч орон зай, хүндийн төвтэй жишин, зураасны бүдүүн, нарийн хэлбэр галбирыг харьцуулж орон зайг тодорхойлно. /зураг 30/

Үүнээс гадна өнгийн гэрэлтэй ба бүдэг, хүнд ба хөнгөн зэрэг нь харьцуулсан байгууламжийн шинж чанарыг тодорхойлоход нөлөө үзүүлдэг.


Сөрөг загварчлал түүний илэрхийлэх хүчин зүйл

Орон зайн хийсвэрлэл /сөрөг загварчлал/ гэдэг нь хавтгай дээр босоо, хэвтээ, налуу зэрэг олон хавтгайг авч орон зайн дүрслэлийг бий болгохыг хэлдэг. Ингэж дүрслэхэд харааны цэг, перспективийн шугамыг ашиглан тухайн биетийн бүтэцийг нэвт харагдахаар, харааны сэрлийн гажуу, хуурмаг ойлголтыг ашиглан хавтгайд дүрсэлдэг.

Зөрчилт орон зай буюу орон зайн хийсвэрлэл бол харааны цэг ба перспективийн шугамыг нэмж, хасах өөрчлөн байгуулах аргаар нэгэн биетийг олон талаас нь зэрэг үзэгдэх байдлаар дүрслэх арга юм. Энэ нь бодит амьдрал дээр байж боломгүй дүрслэлийг зургийн хавтгай дээр дүрслэн үзүүлэх боломжийг олгоно.



Зураг 53



зураг 54

Ийм байгуулалтыг зохиоход тодорхой математик хэмжээг ашигладаг юм. Байгууламжийн нэгж болон үндсэн дүрсийн тэнцүү биш тооны харьцаа нь уран сайхны боловсруулалтын үр дүнд орон зайн гажуу ойлголт буюу төөрөгдлийг үүсгэх бөгөөд биетийн бүтэцийг ил болгож, орон зайг өөрчлөн, гадаад байдлын хэд хэдэн байршил, хувилбарыг нэгэн зургийн хавтгайд төвлөрүүлснээрээ орон зайн сэтгэмж, хийсвэрлэлийг хөгжүүлэхэд чухал алхам болдог.

Хавтгайн зохиомж

Хавтгайн зохиомжийн үндсэн элементүүдийг хэлбэрийн болон зохиомжийн элементүүд гэж хоёр хуваана. Хэлбэрийн элементүүд нь цэг, шулуун, хавтгайгаас бий болно. Зохиомжийн элементүүд нь дүрсүүдийн их бага, чиглэл хөдөлгөөн, бүтэц, тод ба бүдэг өнгө зэргээс бүрдэнэ. Эдгээр үндсэн элементүүдээр тоо томшгүй олон хийсвэр дүрийг бүтээх боломжтой юм.


Дэлхий ертөнц дээрх аливаа юмс үзэгдэл, ургамал амьтан, хүний үйл ажилгаагаар бүтсэн эд агуурс нь бүгд гадаад хэлбэр дүрстэй байх агаад ямарваа эд юмсын гадаад байдлын хэлбэр дүрс нь цэг, шулуун хавтгай, өнгө, гадаргуу зэргээс бүрддэг. Иймээс энэ талаар дэлгэрэнгүй мэдээ гэвэл эдгээрийн мөн чанар онцлогийг судлан шинжлэх хэрэгтэй болно.

Ертөнцийн алив юмсыг бид дүрслэхдээ тухайн зүйлийн бусдаас ялгарах онцлог байдлыг гаргаж үзүүлдэг.

Дүр бүтээх анхдагч элемент – ЦЭГ

1.Цэгийн томъёолол:

Дүрийг зохих талаас авч үзвэл цэг бол аливаа хэлбэр, дүрсийг бүтээх анхдагч элемент юм. Төрөл бүрийн хэмжээтэй, олон цөөн, нягт сийрэг байршилтай цэгүүдийн үндсэн систем дээр орчин үеийн техник, телевиз, компьютер, хэвлэлийн технологи дээр үндэслэн бүтээгддэг байна.



Геометрийн утгаараа цэг нь зөвхөн орон зайд байрлахаас бус их, бага гэсэн ойлголтод хамаарагдахгүй оршдог. Цэгээр хөдөлгөөнт байдалд шулууныг шулууныг, хөдөлгөөн зогсход төгсгөлийг тэмдэглэдэг. Мөн хоёр

шулууны огтлолцоллын үндэн дээр цэг үүснэ.

Цэг нь дүр бүтээх талаас авч үзвэл өөр өөр утга агуулга, учир хобогдолтой аж.

Цэг бол орон зайн байрлал бүхий харааны сэрлийн нэгэн нэгж бөгөөд түүнд түүнд дээр, доор, зүүн, баруун тийш холбогдох болон аливаа нэгэн чиглэлт чанар байдаггүй. Цэгийн их багын хэмжээ нь цэгийн цэгийн хязгаараас давж болохгүй хэрэв үүнээс давбал цэгийн шинж чанараа алдаж хэлбэр буюу хавтгай болно.



Хэлбэрийн тодорхой ялгааг болон хязгаарыг гаргая гэвэл заавал түүний байршилынх нь / адилтгасан / харьцаагаар шийднэ. Жишээ нь : гадаад далай дундах өчүүхэн завь бол цэг шиг үзэгдэнэ. Огторгуйд гялалзах түм буман одод ч цэгийн шинжтэй.

Эртний хятад зураг дээрхи аргад үндэслэсэн “ холын цэг нь мод, ойрийн цэг нь суврага ” гэсэн урлахуй ухааны онолыг бий болгосон. Энэ онолд дүрслэгдэж буй юмсыг цэг хэмээн сэтгэж, цэгийг голлон ашигладаг.

Цэгийн шинж чанар, түүний онцлог

Чимэглэлийн зураг төсөл зохиоход цэг нь хураангуйлах тэлэх үйлдэлтэй байдаг учраас орон зайн шинжтэй. Жишээ нь : барааны зар сурталчилгаа, шошгонд цэгийн энэ үйлдлийг ашигладаг. Энэ ёсоор зарыг төлөвлөн зурахдаа шошгыг харьцангуй өргөн тавьж түүний орон зайг эзлэх үйлдлийг нэмэгдүүлэх, мөртлөө шошгийг улам тодруулдаг байна. Жишээ нь : хятад цэцэг, болжморыг зурах аргад ямагт маш их орон зайн дунд хоёр эрвээхэй юмуу зөгийг тодруулан зурсан байдаг.

Ингэснээр зургийг бүрэн дүүрэн харуулдгаар барахгүй орон зайн мэдрэмжийг нэмэгдүүлдэг онцлогтой. Орон зайн дунд хоёр адил цэг тус тусын орон зайг эзэлж байгаа үед түүний тэлэх хүчний үйлчлэл нь тэр хоёрыг холбосон харааны шугаман дээрээс илэрдэг. Тийнхүү сэтгэхүйн талаас нь авч үзвэл үэгчдийг татах ба холбох үр дүнтэй.




1

2

Хоёр цэг их бага нь адилгүй байхад хүмүүсийн анхаарал том цэг рүү хандаж дараа нь дараа нь жижиг цэг рүү шилждэг. / зураг 1 /

Цэгүүд нь шугаман дээр ижил зайтай жагсаасан үед шулууны мэдрэмжийг өгдөг. /



зураг 2/


Реклам суртлалчилгаа болон сав баглааг төлөвлөхдөө үйлдвэрийн нэр, тайлбарыг бичихэд шулуун дээр ижил хэмжээгээр байрлуулсан цэг буюу үсгийг хэргэлнэ. Хийсвэр шулууныг дээд, доод, баруун, зүүн тийш

хөдөлгөхөд хавтгайн мэдрэмж буй болдог. Харааны сэрлийн ийм аргыг зар сурталчилгаанд өргөн ашигладаг байна. Тайлбар үгийн зохиомж нь нь бүхий л дүрс зургийнхаа дунд өнгө будгийн хослолоор тод харагдах ёстой. Төлөвлөхдөө эдгээр тайлбар бүхий үгийг зураг төслийн бүрэлдэхүүн хэсэг гэж үзэх хэрэгтэй.


/ зураг 4 / Дөрвөлжин доторх дүрс нь цэгийн шинж чанартай ба орчинд нь зохих дүрсүүдийг нэмэх үед нэгэн зүйлийн баганын мэдрэмжийг өгч, цэг нь хавтгай болж хувирна. Ингэснээр цэгийн чанараа алдана.

Ихээс бага уруу аажим шилжсэн байдлаар зар сурталчилгааг зохиомжилж болно. Түүний үгсийн зохиомж нь хийсвэр шулуун бөгөөд хийсвэр хавтгайн санааг төрүүлэх тул эдгээр нь хийсвэр шулуун, хавтгайн зохиомжийн салшгүй хэсэг болж хаьцуулах үйлдэлтэй байна. Хэрвээ цэгийн орчин тойрон нь хувиран өөрчлөгдвөл түүний шинж чанар нь хувирч цэг нь хавтгай болон хувирдаг. Ингэснээр цэгийн шинж чанараа алдана. / зураг 5 /


/ зураг 6 9 / цэгийн орчинг харьцуулан хувиргах үед цэгийн онцлогийг чангаржуулах ба сулруулж болдог. / зураг 6/-д үзүүлсэн 9 ширхэг ижил хэмжээтэй дөрвөлжин цэг нь цөм цэгийн шинж чанарыг илтгэж байна.




6



7



8




9


зурагт тэдгээрийн гадна хүрээний гадна хүрээний 8 цэгийн чиглэлийг өөрчилсөнөөр дунд байсан цэг нь урт дөрвөлжин хэлбэрийн мэдрэмж өгч байна. Зураг 8-д гадна хүрээний цэгүүдийг уртаснаснаар дундах цэгийн онцлогийг улам тодруулсан байна.

Зураг 9-д гадна хүрээний цэгүүдийн онцлогийг чангаруулсанаар дундах цэг нь онцолгоо алдаж урт дөрвөлжин болжээ.

Зураг 10, 11 –д цэг байсан дүрсэд буюу дүрсийн хэлбэр нь элементийг ихэсгэх үед цэгийн хэлбэр нь алдагдаж хавтгайн онцлогийг мэдрүүлдэг ажээ.



10




11


Цэгийн андуу харагдахуй

Цэг нь хавтгай дээрх бусад элементүүд, тэдгээртэй харилцан байрших их багын хаьцаа, хар цагаан, хүнд хөгөн тоны өөрчлөлтөөс хамаарч хүний харааны мэдрэхүйд андуу ташаа хэрэгдэж болдог. Ийм учраас энэ онцлогийг зураач, дизайнерүүд сайн мэддэг, бүтээлдээ зөв ашигладаг байх нь зүйтэй юм.


1. Өнгө тоны өөрчлөлтөөс хамаарч их багын өөрчлөлттэй харагдах.




12




13



14



15





16

Адил хэмжээтэй хоёр тойргийн нэгийг нь хар дэвсгэрт дээр цагаанаар нөгөөг нь цагаан дэвсгэр дээр хараар будаж байрлуулахад, цагаан тойрог нь том, хар нь жижиг болж харагддаг.


2. Хавтгай дээр зэрэгцэн орших бусад элементүүдээс хамаарч их багын өөрчлөлттэй харагдах

Ижил хэмжээтэй дугуй дүрсийг том, жижиг, дугуй дүрсээр хүрээлсэн тохиолдолд том дүрсээр хүрээлүүлсэн нь өөрийн хэмжээнээсээ багассан юм шиг сэтгэгдэл төрүүлдэг.

3. Хавтгай дээрх ташуу элементээс хамаарч их багын өөрчлөлттэй харагдах.
/ зураг 16/
4. Хүрээ зураасны том жижгээс хамаарч их багын өөрчлөлттэй харагдах
Ижил хэмжээтэй хоёр дугуй дүрсийн нэгийг нь хүрээлэхэд орон зай нь багассаны улмаас нөгөөгөөсөө том юм шиг сэтгэгдэл төрүүлдэг.



5. Ар дэвсгэр дүрсийг алаглуулсан будсанаас их багын өөрчлөлттэй харагдах. Том жижиг цэгүүдийн зохиомжийг солбиулан будаж хооронд нь жишэж үзхэд дүрс ба дэвсгэрийн хавтгай дээрх зохиомжууд нь өөр өөр сэтгэгдэл төрүүлж байдаг.



17

18

Шулууны төрөл зүйлүүд

Шулууны томъёолол:Геометрийн томъёололд шулуун бол зөвхөн уртын хэмжээ байхаас өргнө зузааны хэмжээ ч илэрхийлэгддэггүй бөгөөд цэгийн шилжсэн хөдөлгөөн юм. Үүнээс гадна хавтгайн огтлолцол хөвөө тул дүр бүтээх талаас нь авч үзвэл заавал харагдах ёстой. Иймээс шулуун нь зохих байрлалд уртын болон өргөний хэмжээтэй орших учир хавтгайн зохийн бүтээлтэнд зайлшгүй чухал хэсэг болдог.

Шулууныг шулуун болон муруй гэж хоёр хэсэг болгон хуваана. Цэгийн шилжих чиглэл нь тогтвортой үед шулуун шугам болдог бөгөөд харин хувиралттай үед нь муруй шугам болно. Цэгийн шилжих чиглэл нь тасралтгүй хувирах үед “зүрхний бичлэг шиг”шугам үүсэх ба шулуун болон муруй шугамын хооронд байдаг.

Шулуун нь дүрсийг зурах буюу бүтээхэд маш их үүрэг гүйцэтгэдэг. Дорно дахины дүрслэх урлагийн гол онцлог,илтгэх арга нь төрөл бүрийн зураасуудыг чадамгай ашигласанд оршино.

Шулууны шинж чанар, түүний онцлог

Дүрс бүтээхэд шулуун, цэгээсээ нэн илүү сэтгэл хөдөлгөх дүрслэлийн арга юм. Энэ чанар нь уртаасаа шалтгаалах бөгөөд цэгийн шилжих хөдөлгөөнөөр тогтоогдоно. Үүнээс гадна цэгийн шилжих хурд нь шулууны зан төлөвийг тодорхойлно. Жишээ нь:хэрэв шулууныг түргэн зурвал тэгш сайхан, удаан зурсан нь муруй болдог.

Энэхүү худцаас хамаарсан хамаарал шулууны хүчний чанга сулыг илтгэдэг. Хурдыг нэмэх, хасах буюу хурдцын өөр өөр хувиралт болоод чиглэлийн өөрчлөлт нь зүйл бүрийн шинж чанарыг илтгэнэ. Шулууны шинжийг тодорхойлоход шулуун зураас нь тогтвортойг, муруй зураас нь хөдөлгөөнийг, нугарч хугарсан зураас нь хурц догшин байдлыг тус тус илтгэнэ. /зураг 80,81/

Шулууны төрөл зүйлүүд

Шулуун шугам бол эр хүйстний бэлгэдэл. Мөн тодорхой тууш шулуун зан чанартай болохоор нэг төрлийн хүчний гоо сайхныг төлөөлнө. Үүнд:бүдүүн шулуун нь хүнд, нүсэр болхидуу, нарийн зураас нь цэвэр цэмцгэр, хурц сэргэлэн, мэдрэмтгий, хөрөөний шүд шиг шулуунууд нь санаа сэтгэл түгшсэн айдсын байдлыг илэрхийлдэг. Шулууны чиглэлийг авч үзвэл янз бүрийн чиглэл бүхий шулуунууд өөр өөр шинж чанарыг тусгадаг. Үүнийг тухайн хэрэглээнд тохируулж ашигладаг.

Эгц шулуун /босоо/ нь :эрс шударга, хянуур нямбай, эрхэм дээд, хатуу чанга, шууд шулуун шинж төрхтэй.

Хэвтээ шулуун нь:тайван тогтуун, тогтвортой, эл хуль ядмаг мэдрэмж төрүүлнэ,

Ташуу шулуун нь:нисэж дүүлсэн, урагш тэмүүлсэн, хөдөлгөөнт сэтгэгдэл үүсгэдэг. Босоо шулуун нь хүмүүсийн тархинд тусахдаа тэгш төв дүрсийг бодогдуулдаг бол хэвтээ шулуун нь салхигүй тогтуун, нуурын мандал буюу хэвтэж амрах дүр агшныг санагдуулна. Ташуу шугам нь гүйлтийн тамирчны гараанаас гарах, нисэх онгоцны газраас хөөрөх, мөсөнд тэшигчидийн дүр байдал, хүндийн төвийг урагш шилжүүлж дайран, урагшлах хүчийг илтгэдэг. Шулууны орон зай дахь шинж байдал нь урт, товир бөгөөд бадриун бол хүмүүст урагш түрсэн, итгэлтэй ойр сэтгэгдэл төрүүлнэ. Энэ нь байгалийн үзэгдэлд байдаг ойр байгаа нь том хол байгаа нь жижиг болж харагдах юмуу эсвэл ойр байгаа нь бодитой, хол байгаа нь хийсвэр харагдах орон зайн үзэгдлээс эхлэлтэй.

Геометрийн муруй

Геометрийн муруй шугам гэдэг нь гортигоор байгуулсан муруй шугамыг хэлнэ. Эмэгтэй хүний зан чанарын бэлгэдэл. Шулуунаас харьцангуй эелдэг, дулаахан зан төлөвийг илэрхийлдэг. Муруй шугам нь нэгэн зүйлийн худцын мэдрэмжтэй байх бөгөөд хөдөлгөөнтэй, уян харимхай, эрхэмсэг намуу аястай. Геометрийн муруйн нийтлэг илрэл нь тойрог дүрс бөгөөд тэгш хэмт, эмх цэгцтэй. Бид зохиомжийн явцад тойргийн элементийг ажиглаж, боловсруулснаар харьцагнгүй сайн үр дүнд хүрдэг. /зураг 82/

Зүүн талынх нь ижил төвт тойргоос бүрдсэн дүрс , баруун талынх нь босоо болоод хэвтээ тэнхлэгийн огтлолд огтлолцож, дараа нь цацраг хэлбэрээр байрыг нь сольж байрлуулсан шинэ дүрс юм. Эндээс үзэхэд тойрог бол хэт их эмх цэгцтэй, тэгш хэмтэй дүрс байдгаас төдийлөн хүчтэй сэтгэгдэл төрүүлдэггүй. Мушгиа эргүүлэг дүрс, зууван өндгөн хэлбэрт угалз, эмгэн хумсны дүрсүүдэд хамгийн өргөнөөр хэрэглэгддэг. /зураг 83/

Чөлөөт муруй

Энэ нь гортигоор зурах аргагүй, зөвхөн гараар хийх ба чөлөөт муруй зураасны онцлогыг нэн илүү хадгалсан, чөлөөтэй, хээнцэр эмэгтэй хүний уян чанарыг бэлгэдэж байдаг. Чөлөөт муруй зураас болон шулуун шугам нь гараар

зурсан, болон хэрэглэсэн багажийн онцлогоос хамааран маш олон янзын өөр өөр зан төлөвийг илэрхийлсэн зурааснуудыг бий болгодог. Жишээ нь: хатуу ба зөөлөн харандаа, нарийн бүдүүн үзэг, хуурай нойтон бийр болоод тосон пастель, хулсан бийр, ган үзэг зэрэг багажаар зурсан, хатуу бийрээр хурдтай татсан зураасны ор мөр зэрэг нь өөр өөрийн өвөрмөц байдлыг илтгэнэ. /зураг 84/

7-н төрлийн зураасыг үзүүлэв.

- 1.гараар зурсан
- 2.шугамаар зурсан
- 3.бүдүүн бийрийн
- 4.зурж гаргасан ором
- 5.тосон пастелиар зурсан
- 6.будгаар буюу хуурай будгаар татаж гаргасан
- 7.будаг нэвчисэн.

Шулууны андуу харагдах

Шулуун нь хавтгай дээрх элементүүдтэй харилцан байрших, босоо ба хөндлөн, ташуу, муруй, тасархай зэргээс хамаарч өөр өөр хэмжээтэй харагдаж байдаг.

/зураг 85/ Хоёр тал тэнцүү урттай шулууны эхний шулууныг гадагш чиглэсэн сумаар, дараагийн шулууныг дотогш чиглэсэн сумаар холбоход дотогш чиглэсэн сумтай нь урт болж харагдана.

/зураг 86/ Тэнцүү урттай 2 шулууны, босоо чиглэлийн шулууныг хэвтээ шулуун дээр байрлуулахад босоо шулуун нь хэвтээгээсээ урт мэт харагдана.

/зураг 87/ Тэнцүү урттай 2 хэрчмийг урт богино хэрчмээр ижил хэмжээтэй нэг шулуунд байрлуулахад, богино хэрчмийн дундах шулуун нь урт хэрчмийн дунд байгаа шулуунаас урт болж харагддаг.

/зураг 88/ Хоёр паралель шулуун эсвэл босоо баганыг, огтлон гаргасан ташуу шулуун нь үнэн хэрэгтээ нэг шулуун хэрнээ 2 өөр шулуун шиг санагдуулахаар болжээ.

/зураг 89/ Хоёр талаасаа цацрсан шулуунуудын голд байгаа 2 паралель шулуун нь голоороо хотгор мэт үзэгдэнэ.

/зураг 90/ Нэг цэгээс цацарсан шулууны голд байгаа хоёр паралель шулуун нь голоороо гүдгэр болж харагдаж байна.

/зураг 91/ Шоо дөрвөлжин торон байгууламжийн гадна хүрээнд тулсан тойрог муруй нь байгууламжийн хүрээг гүдгэр харагдуулна.

/зураг 92/ Шоо торон байгууламжийн гадна хүрээнд тулсан шовх муруй нь байгууламжийн хүрээг хотгор мэт болгожээ.

Шулууныг уран сайхны зураг төсөлд хэрэглэх нь

Зар сурталчилгааны зурагт хуудас, сав баглаа, боодол, бүтээгдэхүүний шошго, барааны тэмдэг зэрэгт заримдаа шулуун зураасыг өргөн хэрэглэнэ.

/зураг 93/ Концертийн зар. Энэ нь төвөөс зугатах геометрийн /зохих дараалаар/ чиглэлийн хувирал ашиглаж хийсэн бүтээл бөгөөд эргэж буй муруй шугамын чиглэлийн өөрчлөлөөр хэмнэл болоод аажим аяс , орон зай мэдрэмж оруулсан нь хөгжмийн ая, намбыг илэрхийлэх оновчтой арга болжээ.

/зураг 94/ “Эрчим хүчний өөрийн өртөг болоод түүний хамаарал” гэдэг номын хавтасны чимэг зураг. Хэрэглэсэн дүрслэлийн элемент нь хоёр хэсэг ташуу чиглэлээр жагсаасан бүдүүн шугамууд, хэвтээ чиглэл дээрхи нягт сийргийн харьцааг тусгажээ.

/зураг 95/ Концертийн зарлал. Нарийн бүдүүн нь хоорондоо адилгүй, олон жижиг төвт тойргоор их бага нь адилгүй нум хэлбэрээр бүтсэн тэдгээр шугамуудын эхлэл, төгсгөл нь зохих жам ёсоор байршиж нягт сийргийн харьцааг тодорхой үзүүлсэн байна.


/зураг 97/ Женев хотын хөгжмийн ордны эмблем Каспер Брекманы зохиосон энэ тэмдэг нь өөр чиглэл бүхий хоёр цацраг хэлбэрийн геометрийн муруй шугамнаас бүтсэн байна.

/зураг 96/ Францын агаарын тээврийн компаны зурагт хуудас. Жак Надон Кармоны чөлөөт муруй зураасуудаар 3 тагтааг чөлөөтэй хөдөлгөөнтэй, оновчтой байрлуулсанаар тэнгэр, огторгуй болоод нисэх агуулгыг бэлгэдэжээ.


/зураг 98/ Японы зураачийн бүтээсэн Токиогийн симфони хамтлагын зурагт хуудас жигд жагссан шулуунуудаар чиглэлийг нь солибцуулан өөрчилж орон зайн мэдрэмжийг чадварлаг илэрхийлсэн байна.

Тэгш ба ташуу зураасны сэтгэхүйд нөлөөлөх үйлдэл

Тэгш зураас гэсэн ойлголтонд зохиомжийн хавтгайн талууд болох урт өргөнтэй паралель босоо болон хэвтээ шулуунуудыг хамруулан авч үзэж болдогбосоо болон хэвтээ шулуунууд нь хүнд харьцангуй тогтвортой байдлыг төрүүлнэ. Харин зураасны өөрчлөлт хувирал их, хазайлтын өнцөг нь харилцан адилгүй байх тусам эмх замбараагүй мэт сэтгэгдэл төрүүлэх нь элбэг иймээс ташуу зурааснуудын хазайлтын өнцөгийг багасгаж зураасны чиглэлийн ялгааг ойртуулсанаар харьцангуй сайн үр дүнд хүрнэ. /зураг 99/ нь босоо, хөндлөн, ташуу зурааснуудын нэгдлээр бүтжээ.



Зураг 99




зураг 100




зураг 101

Хэрвээ уртаараа адилгүй хоёр ташуу зураас нэмбэл зохиомж нь харьцангуй амьлаг болж зураасны хувирал баяжсанаар уран сэтгэлгээтэй болно. Дараах дөрвөн зургуудад, ташуу, босоо болон хөндлөн зураасны хооронд давхцсан өнцөг бий болсноор харилцан шүтэлцээтэй гурвалжин үүссэн байна.



Зураг 102



зураг 103

Зохиомжийн хэмнэл айзам баяжиж илүү амьлаг чадварлаг болсон байна. Жишээ нь: /зураг 100/-д босоо ба хөндлөн тэнхлэгт харилцан сүлжилдсэн 6 паралель ташуу шулуун зурсанаар дээд доод талдаа тэгш өнцөгт гурвалжин бүхий дэс дараалалтай зүй тогтолтой зохиомж бий болжээ. Харин /зураг 101, 102, 103/-т гурвалжинг зургийн хоосон зайнуудад тараан харилцан адилгүй хэмжээтэй хооронд нь шүтэлцүүлэн байрлуулсан байна.